



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Нийслэлийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2024 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: НТАГ-2025/019/НА-СТА-ЗГТС

Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2025 он	НТАГ-ын Дэд дарга: Ч.Болд Утас: Цахим хаяг: boldch@audit.gov.mn СНАХ-ийн дарга Х.Түвшинбаяр Утас: 315558 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn Аудитын менежер: С.Гантөгс Утас: 325093 Цахим хаяг: gantugss@audit.gov.mn Аудитор: Б.Одончимэг Утас: 325093 Цахим хаяг: odonchimegb@audit.gov.mn
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас:7000 7734, Факс: (976-11) 32 01 54
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2025.02.25 № 01/119
танай _____-ны № _____-т

НИЙСЛЭЛИЙН ХӨДӨЛМӨР
ХАЛАМЖИЙН ГАЗРЫН ДАРГА,
М.МӨНХБАЯР ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Нийслэлийн Хөдөлмөр, эрхлэлтийг дэмжих сангийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд 98,768.3 мянган төгрөгийн авлагын үлдэгдэлтэй үүнээс 16,368.3 мянган төгрөгийн авлага хугацаа хэтэрсэн авлага байна. Хугацаа хэтэрсэн авлагын 13,623.3 мянган төгрөгийн авлага нь эргэн төлөгдөх нөхцөлтэй олгосон санхүүгийн дэмжлэгийн авлага, 2,745.0 мянган төрөг нь бусад аж ахуйн нэгж байгууллагаас авах тооцоо нийлээгүй авлага байна.

Аудитын гол асуудал

Материаллаг буруу илэрхийллийн эрсдэлд тайлант хугацаанд гарсан нөлөө бүхий удирдлагын шийдвэр, ажил гүйлгээ, үйл явдал үүсээгүй болно.

Бусад асуудлын хэсэг

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	756,946,170.05	98,768,328.16
33	АВЛАГА	756,946,170.05	98,768,328.16
33300	Татаас, санхүүжилтийн авлага	634,577,841.89	-
335	Бусад авлага	122,368,328.16	98,768,328.16
3351	Байгууллагаас авах авлага	2,745,000.00	2,745,000.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	119,623,328.16	96,023,328.16
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	756,946,170.05	98,768,328.16
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	756,941,670.05	98,768,328.16
51	Засгийн газрын хувь оролцоо	756,941,670.05	98,768,328.16
512	Хуримтлагдсан үр дүн	756,941,670.05	98,768,328.16
51210	Өмнөх үеийн үр дүн	97,684,500.00	756,946,170.05
51220	Тайлант үеийн үр дүн	659,257,170.05	(658,177,841.89)
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	756,941,670.05	98,768,328.16

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,502,866,500.00	3,980,000.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	3,980,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	-	3,980,000.00
120009	Бусад орлого	-	3,980,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,502,866,500.00	-
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,502,866,500.00	-
131006	Засгийн газрын тусгай сангаас санхүүжих	1,502,866,500.00	-
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	843,609,329.95	662,157,841.89
21	УРСГАЛ ЗАРДАЛ	843,609,329.95	662,157,841.89
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	116,958,490.00	-

Нийслэлийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	116,958,490.00	-
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	116,958,490.00	-
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	726,650,839.95	662,157,841.89
2132	Бусад урсгал шилжүүлэг	700,430,168.11	-
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	700,430,168.11	-
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	634,577,841.89
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	634,577,841.89
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	3,980,000.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	3,980,000.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	26,220,671.84	23,600,000.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	26,220,671.84	23,600,000.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	659,257,170.05	(658,177,841.89)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	659,257,170.05	(658,177,841.89)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,502,866,500.00	638,557,841.89
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	638,557,841.89
120	Нийтлэг татварын бус орлого	-	638,557,841.89
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	634,577,841.89
1200043	Урьд оны үлдэгдэлээс санхүүжих	-	634,577,841.89
120009	Бусад орлого	-	3,980,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,502,866,500.00	-
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,502,866,500.00	-
131006	Засгийн газрын тусгай сангаас санхүүжих	1,502,866,500.00	-
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,530,187,171.84	662,157,841.89
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,530,187,171.84	662,157,841.89
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	116,958,490.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	116,958,490.00	-
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	116,958,490.00	-
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,413,228,681.84	662,157,841.89

Нийслэлийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2132	Бусад урсгал шилжүүлэг	752,430,168.11	-
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	752,430,168.11	-
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	634,577,841.89	634,577,841.89
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	634,577,841.89	634,577,841.89
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	3,980,000.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	3,980,000.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	26,220,671.84	23,600,000.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	26,220,671.84	23,600,000.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	(27,320,671.84)	(23,600,000.00)
14	Бусад эх үүсвэр	27,320,671.84	23,600,000.00
145004	Дотоод эх үүсвэрээс олгосон зээлээс эргэж төлөгдөх	27,320,671.84	23,600,000.00
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	27,320,671.84	23,600,000.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	97,684,500.00	97,684,500.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	97,684,500.00	97,684,500.00
C07	Тайлант үеийн үр дүн	659,257,170.05	659,257,170.05
C08	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	756,941,670.05	756,941,670.05
D01	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	756,941,670.05	756,941,670.05
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	756,941,670.05	756,941,670.05
D08	Тайлант үеийн үр дүн	-658,177,841.89	-658,177,841.89
D09	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	98,763,828.16	98,763,828.16

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайланд онд тус санд төсөв батлагдаагүй байх тул гүйцэтгэл гараагүй байна.

ГУРАВ. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар 3,980.0 мянган төгрөгийн 1 алдаа¹ илэрснийг аудитын явцад залрууллаа.

Аудитаар нийт 9,415.0 мянган төгрөгийн зөрчил² илэрснээс 2,745.0 мянган төгрөгийн 1 зөрчлийг арилгуулах, зөрчлийг давтан гаргахгүй ажиллах 1 албан шаардлага, 6,670.0 мянган төгрөгийн 1 зөвлөмж хүргүүлээ.

Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс						Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй					
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Нийслэлийн ХЭДС	1	3,980.0			1	3,980.0	1	3,980.0						
Дүн	1	3,980.0			1	3,980.0	1	3,980.0						

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Нийслэлийн ХЭДС	2	9,415.0			1	2,745.0	1	6,670.0				
Дүн	2	9,415.0			1	2,745.0	1	6,670.0				

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр				
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Өөрчлөлтгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан	
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй					
A	1	2	3	4	5	7	8	9	10	
1	ТШЗ	1	1			1				
	НИЙТ	1	1			1				

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.